

## ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

## STATE BORDER POLICY AND SECURITY



ХИЛ СУДЛАЛ

Д.Алтангэрэл\*

Дотоод хэргийн их сургуулийн Захиргааны удирдлагын газрын дарга, докторант, хурандаа  
Col. Altangerel D, Ph.D Candidate, Head, Department of Administrative Management,  
University of Internal Affairs

\*Хариуцлагатай зохиогч: altangerel.d@uia.gov.mn

**Хураангуй:** Төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хил хамгаалалтын механизмуудыг хангахад чиглэсэн чухал баримт бичиг юм. Энэ бодлого нь улс орон даяар олон хүчин зүйлсийг уялдуулан боловсруулагддаг бөгөөд улс төр, эдийн засаг, цэрэг, хууль эрх зүйн нөхцөл байдал болон дотоод, гадаад хүчин зүйлсээс хамааран тодорхойлогддог.

Төрөөс баримтлах энэ бодлого нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, газар нутгийн халдашгүй дархан байдлыг хангахад чиглэж, улсын аюулгүй байдлыг дотоод болон гадаад түвшинд баталгаажуулах үндсэн механизмуудыг бүрдүүлдэг.

Мөн энэ бодлого нь олон улсын гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжийг хослуулан хөгжүүлж, хилийн асуудлыг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор хэрэгжиж байна. Үүний үр дүнд, Монгол Улсын хил хамгаалалтын бодлого нь зөвхөн улсын аюулгүй байдлыг хангахад төдийгүй, улс хоорондын харилцааг зохицуулах гүүр болж, олон улсын хэмжээнд улс орны бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үүрэг гүйцэтгэдэг.

Мэдээллийн эрин зуунд терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг асуудлууд улс орны аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдалд шууд нөлөөлж буй тул манай улс хил хязгаартаа аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаагаа боловсронгуй болгоход онцгой анхаарах шаардлагатай болжээ.

**Abstract:** The state border policy is an important document aimed at ensuring the country's security, independence, territorial integrity, and border protection mechanisms. This policy is developed in coordination with many factors across the country and is determined by the political, economic, military, and legal situation, as well as internal and external factors.

This government policy is aimed at ensuring Mongolia's independence, sovereignty, border area security, and territorial inviolability, and forms the main mechanisms for ensuring national security at the internal and external levels.

Also, this policy is being implemented in order to develop a combination of international agreements and laws and create a legal framework for regulating border issues. As a result, Mongolia's border protection policy not only ensures national security, but also plays an important role as a bridge to coordinate relations between countries and ensure the integrity and security of the country at the international level.

In the information age, problems such as terrorism and transnational organized crime directly affect the security of the country and the stability of the region, so our country needs to pay special attention to improving its policies and activities to ensure security at its borders.

**Түлхүүр үгс:** Төрөөс хилийн талаарх бодлого, хил хамгаалалт, аюулгүй байдал, хөрш улс, хил орчмын нутаг дэвсгэр, олон улсын гэрээ, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал

**Keywords:** Government policy on borders, border protection, security, neighboring countries, border areas, international agreements, territorial integrity

### Үндсэн хэсэг

Дэлхийн дахинд болон бүс нутагт аюулгүй байдлын орчин улам бүр ээдрээтэй болж байгаа энэ цаг үед хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюул, эрсдэлийг даван туулах, бэлэн байх, улсын хилийн халдашгүй дархан байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангахад улс орон бүр анхаарал хандуулж байгаа бөгөөд түүний нэг илрэл нь нэг улсын эрх ашиг, аюулгүй байдал гэхээсээ нэгдмэл байх, нийтлэг эрх ашиг, хамтын аюулгүй байдлыг урьтал болгохыг чухалчлах боллоо.

Монгол Улс нь өнө эртнээс (Их Монгол улс) өнөөдрийг хүртэлх түүхийн цаг хугацаанд улсын хилийн асуудлаа онцгойлон авч үзэж, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад чиглэгдсэн бодлого, үйл ажиллагааг тасралтгүй авч хэрэгжүүлсээр өнөөг хүрчээ.

Монгол Улс 1970-1980-аад онд анхны хилийн хууль, 1990-ээд онд шинэчлэгдсэн хилийн тухай хууль зэргийг баталж, хил хамгаалалтыг зохицуулж байсан бол эдгээр хууль нь цаг үеийн нөхцөл байдал, улс орны хөгжилд тохирсон шинэчлэлийг шаардсан. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг, зорилтууд нь эхлээд цэргийн болон хил хамгаалах байгууламжийн үйл ажиллагаа, мөн эдийн засаг, нийгэм, дотоодын аюулгүй байдлын асуудлуудыг хамардаг.

Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль эрх зүйн шинэтгэл, төрийн цэргийн болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын шинэчлэлтэй холбоотойгоор төрийн бодлого, эрх зүйн багц баримт бичгүүд шинэчлэгдэн батлагдаж, эрх зүйн орчин бүрдсээр байна. Өөрөөр хэлбэл, 20 гаруй жил мөрдөгдөж байгаа Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг шинээр найруулах шаардлага бодитой үүссэн байна.

Монгол Улс олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хамтын ажиллагаа, дипломат хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэж ирсэн бөгөөд энэ нь хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хилийн асуудлыг зохицуулах олон улсын гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хөрш орнуудтай итгэлцэлтэй харилцах бодлогын нэг хэсэг болдог.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг улс орны аюулгүй байдлын /үндэсний аюулгүй байдал/ үзэл баримтлал болон улс төрийн бодлогын салшгүй хэсэг байх ёстой гэж дэлхийн хамтын нийгэмлэг үздэг байна.

Монгол Улсад Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүнд нийцүүлэн шинэчлэн гарсан 680 гаруй хууль өнөөдрийн нийгмийн харилцааг зохицуулж байна. Эдгээрээс улсын хил, түүний хамгаалалт, хилийн цэргийн алба, үйл ажиллагаатай холбогдсон шууд хамааралтай 70 гаруй хууль, шууд бус хамааралтай 30 гаруй хуулиуд тус тус хэрэгжиж байгаа болно. Хилийн аюулгүй байдлыг хангах, улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж явуулахтай холбоотой эрх зүйн орчны өмнөх түүх, хэрэгжиж ирсэн цаг хугацааг авч үзэхэд дараах нөхцөл байдлыг туулж ирсэн байна.

Улсын хил, хилийн харилцаа, хил хамгаалах байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт болон хилийн асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулах бодит шаардлагыг харгалзан БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1973 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 161 дүгээр зарлигаар анхны “БНМАУ-ын Хил хамгаалах хууль”-ийг батлан мөрдүүлж байжээ. Уг хууль нь Монгол Улсын хилийн харилцаатай холбоотой асуудлыг зохицуулах эрх зүйн шинэ орчин бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой байсан.

Түүнчлэн цэргийн шинэчлэлийн бодлого эрчимжсэн, улсын хилийн талаар тухайн үеийн нам, эвсэл, холбоод, төрийн бус байгууллагууд элдэв санал бодлоо илэрхийлэх, иргэдээс хил залгаа улс болон бусад улс орнуудад зорчих явдал эрс нэмэгдсэн, хилийн цэргийн залуу офицерууд албанаас гарах, зах зээл рүү шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй боловсон



МОНГОЛ УЛСЫН  
ХАМТЫН АЮУЛГҮЙ  
БАЙДАЛЫН  
ХАМГААЛАХ  
ХУУЛЬ



ХИЛ СУДЛАЛ

хүчний тогтвортой байдал алдагдаж, улсын хил дээр гэмт хэрэг, ноцтой зөрчил гарах явдал эрс нэмэгдсэн зэрэг хүчин зүйлүүдээс үндэслэн 1993 онд шинэ “Хилийн тухай хууль”-ийг боловсруулж, батлуулан мөрдөж эхэлсэн байна.

Энэ хууль нь шилжилтийн үед Монгол Улсын хил, түүний халдашгүй дархан байдлыг хангах, хил хамгаалалтын тогтолцоог шинэ нөхцөл байдалд зохион байгуулах, мөн хил хамгаалах байгууллагын бүтэц, үйл ажиллагааг тогтвортой байдалд шилжүүлэхэд чиглэгдэж, эдгээр асуудлуудыг амжилттай шийдвэрлэснээр агуулга, үзэл санаа нь өнөөдрийг хүртэл хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын бүтэц, агуулгатай холбогдож, тухайн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн суурь болж байна.

Энэхүү баримт бичиг нь улсын хил, түүний аюулгүйн асуудалд хамаарах нийгэм, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зүйн хүрээг хамарсан өргөн агуулгатай, залгамж чанартай Монгол төрийн бодлого мөн.

Бодлогод хязгаар нутгийг эрчимтэй хөгжүүлэх, улсын хилийг мэргэшсэн хилчид, техник хэрэгсэл хосолсон, улс төр дипломатын арга голчилсон хамгаалалттай болгох, түүнд төрийн байгууллагууд, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангаж, хил нээлттэй, энхийн байх үзэл санааг агуулсан дараах зарчмын гол заалтууд тусгагдсан байна. Үүнд:

- улсын хилийн асуудлаар баримтлах төрийн бодлого нэгдмэл, явуулж буй үйл ажиллагаа уялдан зохицож байх эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

- нэгэнт тогтсон хил өөрчлөгдөхгүй, түүний халдашгүй дархан байдал хангагдсан байх нөхцөлийг бүрдүүлэх;

- хилийн аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэж байхыг эрмэлзсэн Монгол төрийн албан ёсны байр суурийг илэрхийлсэн байх;

- хязгаар нутаг, түүнийг хөгжүүлэх, тэнд ажиллаж, амьдрагсдын

нийгмийн баталгааг хангах талаар баримтлах төрийн үзэл баримтлалыг тодорхойлох;

- улсын хил хамгаалалтад оролцох чиг, үүрэг бүхий бүх байгууллагуудад мөрдөгдөж буй хууль тогтоомжуудыг улсын хил хамгаалалтын эрх ашигт нийцүүлэх, тэдний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах механизм бүрдүүлэх;

- улсын хил хамгаалалтад хяналтын болон илрүүлэлтийн зориулалттай техник хэрэгслийг өргөн нэвтрүүлэх, аль болох хэмнэлттэй, үр өгөөж сайтай аргыг түлхүү ашиглах асуудлыг чухалчлах;

- улсын хил хамгаалах байгууллагын чиг үүрэг, харьяалал, бүтэц зохион байгуулалт, бүрэлдэхүүн, зэвсэглэл, хангалтын байдлыг сайжруулах, улсын хил хамгаалалтад тэдний эзлэх байр суурийг өндөржүүлэх, бие даасан ажиллагаа, боломж, чадавхыг дээшлүүлэх асуудлыг баталгаажуулах;

- улсын хил хамгаалалтад оролцогч байгууллага, иргэдийн нийгмийн хангамж, баталгааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авах зэрэг болно.

### **Хил хамгаалах байгууллага, хөгжлийн чиг хандлага**

Хил хамгаалах байгууллага (ХХБ) гэсэн ойлголтыг олон улсын хэмжээнд хэрхэн тодорхойлдог эсэхийг зарим улсуудын жишээн дээр тодруулах, хилийн цагийн байдал хамгийн өрнөлттэй, хил дамнасан зөрчил, гэмт хэрэг ихтэй, технологийн болон эдийн засгийн өндөр хөгжилтэй болон бусад орнуудын ХХБ-ын ойлголт, хөгжлийн хандлага өөр өөр байгаа бөгөөд тэдгээрийг харьцуулснаар олон улсын хэмжээнд ХХБ-ын хөгжил хааш чиглэж байгаа нь харагдах юм.

Төрийн хилийн бодлого нь улс орны амьдралын бүхий л салбар дахь асуудлуудыг хилийн орон зайд шийдвэрлэх чиглэлтэй байдаг. Энэ бодлогыг хэрэгжүүлэх шаардлага нь тухайн улс орны гадаад болон дотоод хүчин зүйлсээс хамаардаг. Тухайлбал:

Гадаад хүчин зүйлс:

АНУ-ын хувьд, Мексик болон Карибын тэнгисийн орнуудтай харилцах

харилцаанд гарсан зөрчилдөөнтэй асуудлууд нь хил хамгаалалтын бодлогын үндсэн чиглэлд нөлөөлж байна. Энэ нь хилийн аюулгүй байдал, хууль бус миграци, мансууруулах бодисын тээвэр зэрэг асуудлуудаар илэрч, хууль сахиулах үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлага үүсгэж байна.

Европын холбооны орнууд-ын хувьд, хил орчмын нутаг дэвсгэрийг хүчээр булаан эзэлж байсан түүх болон одоогийн газар нутгийн маргаан, улс төрийн асуудлууд нь хилийн бодлого, дипломат харилцааг нэлээд төвөгтэй болгож байна.

ОХУ-ын хувьд, Тодорхойгүй хилийн хэсгүүд: Зарим хөрш орнуудтайгаа улсын хилийн зарим хэсгийг тодорхойлж, тогтоогоогүй байгаа асуудал ОХУ-ын хилийн бодлогод нөлөөлдөг. Энэ нь хоёр талын харилцаанд маргаан үүсгэх, хилийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулах боломжтой.

Хилийн зөрчил болон мөргөлдөөн: ОХУ-ын хил дээр байнгын маргаан, зөрчилдөөнтэй асуудлууд үүсэж, энэ нь томоохон улс хоорондын мөргөлдөөнд хүргэж болзошгүй байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэх нь хилийн тогтвортой байдлыг хангахад чухал.

Өмнөх төрийн тогтолцооны бодлогоос татгалзах: ЗСБНХУ-ын үед хэрэгжиж байсан хилийн "төмөр хөшиг"-ний бодлогоо орхигдуулж, илүү нээлттэй, хамтын ажиллагаанд тулгуурласан хилийн бодлого хэрэгжүүлэх шаардлага гарсан.

Гадаад хилийн хамгаалалт: ОХУ нь өөрийн улсын гадаад хилийг хамгаалахын зэрэгцээ, тусгаар тогтносон хамтын нөхөрлөлийн (ТТХН) орнуудын гадаад хилийг хамгаалах үүрэгтэй болсон. Энэ нь улс орон бүрийн аюулгүй байдал, хил хамгаалалтыг хариуцаж байгаа байдлыг илтгэдэг.

Хилийн албаны шинэчлэл: ОХУ-ын Холбооны Хилийн Албаны үүрэг нь улам өргөжиж, хууль бус цагаачлал болон хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдэж байна. Энэ нь хил хамгаалалтын үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж, олон улсын аюулгүй байдалд нөлөөлөхүйц чухал асуудал болж байна.

ОХУ нь Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, түүний хэрэгжилтийг хангах зорилгоор Аюулгүй байдлын зөвлөлийн байнгын комиссын хилийн бодлого хариуцсан байгууллага, түүний бүтцэд 17 төрийн яам, агентлаг, албыг оруулсан байна.

Энэ нь улсын хил хамгаалалт зөвхөн Хилийн албаны байгууллагын үүрэг биш гэдгийг харуулж байна. Тэрээр эдийн засаг, үндэстэн, нийгэм улс төр, цэрэг, экологи, техник, соёл, ертөнцийг үзэх үзэл, оюун санаа ухамсрын гэх мэт бусад олон чиглэлүүдийг нэгтгэж бас сөргөлдүүлж байдаг салбар юм.

Төрийн хилийн бодлогын ач холбогдол: Орчин үед улс орон бүр өөрийн төрийн тэргүүнээр батлуулсан, олон улсын хуулиудтай нийцсэн төрийн хилийн бодлоготой байх нь зайлшгүй шаардлага болж байна. Тус бодлого нь тухайн улсын эдийн засаг, аюулгүй байдал, дипломат харилцаа, хилийн маргаан шийдвэрлэх болон хилийн орон зайд хууль бус үйл ажиллагаа үүсэхээс сэргийлэх чиглэлд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэхүү улс төрийн чухал бичиг баримт нь тухайн улсын хөрш орнуудтай баримтлах хилийн асуудал, хилийн аливаа маргаан, зөрчилдөөнтэй асуудлыг шийдвэрлэх үндсэн чиглэлүүдийг тусгадаг. Энэ нь улс орнуудын хилийн аюулгүй байдал, тэдгээрийн хоорондох хамтын ажиллагаа, мөн олон улсын хууль зүйн хүрээнд шийдвэрлэгдэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, хилийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

БНХАУ-ын Төрийн зөвлөл, Цэргийн төв зөвлөлийн 1973 оны тогтоол Монгол, Зөвлөлт, Солонгос, Вьетнам, Лаос, Пакистан, Непал улсуудын талаар баримтлах Хилийн төрийн бодлого, 1983 онд Энэтхэг, Бутан, Бирм улсуудын талаар баримтлах Хилийн төрийн бодлого, БНХАУ-д зорчих гадаадын иргэдийн тухай хууль, БНХАУ-ын иргэдийн улсын хилээр нэвтрэх тухай хууль, Улсын харьяатын тухай хууль, Боомтын тухай хууль, 2020 онд батлагдсан БНХАУ-ын Хуурай газрын хилийн тухай хуулиар хил хамгаалалт,



МОНГОЛЫН  
Дотоод  
Асуудлын  
Төрийн  
Холбооны  
Хилийн  
Албаны  
Төрийн  
Бодлого





ХИЛ СУДЛАЛ

шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааг зохицуулж байна.

**Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт:** “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” нь улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн аюулгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, улсын хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болж, дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Хилийн стратегийн бодлогын баримт бичгийн түүхэн үүрэг, хуулийн дагуу хилийн аюулгүй байдлыг хамгаалахад зориулсан хүчин чармайлт нь одоогоор тодорхой хэмжээгээр амжилттай байгаа ч, хэрэгжилтийн тал дээр олон саад бэрхшээл бий.

Монгол Улсын хил хамгаалалт, үүнийг хэрэгжүүлэх нэгдмэл тогтолцоо нь эрх зүйн бичиг баримтуудаар батлагдсан хэдий ч, амьдралд хэрэгжих нь хангалтгүй, уялдуулан зохицуулах үүрэгтэй төрийн институтууд нь ил тод уялдаа холбоогүй, нэг чигт харсан үйл ажиллагаа дутмаг байгаагаас үр дүнд хүрэхэд хүндрэл учирч байна. Энэ байдал нь хуульд заасан үндсэн үүргээ биелүүлж чадахгүй байгаа байдлаар төдийгүй, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн итгэл алдагдаж, шүүмжлэлд өртөж байгаа нь харамсалтай.

Хил хамгаалалтын бодлого нь олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд нийцсэн байх ёстой. Энэ нь хил хамгаалалтын үйл ажиллагааг улс орны амьдралын бүхий л салбаруудаас тусгаарлаагүй, харин зохицуулалттай, харилцан уялдаатай байхаар төлөвлөгдсөн байх ёстой. Монгол Улсын хил хамгаалалтыг зохион байгуулж буй хууль тогтоомж нь холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрүүдтэй уялдуулан хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь улс хоорондын харилцааны тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Бодлогын гол зорилго нь Монгол Улсын хил, түүний аюулгүй байдлыг хангах, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг сайжруулах, хөрш

орнуудтай харилцан итгэлцэлтэй байх замаар улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, цаашид улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах явдал юм. Мөн энэ бодлого нь "нэг хил, хоёр улс" зарчмыг баримтлах замаар улс хоорондын итгэлцлийг бэхжүүлэх зорилготой.

Улсын хил, түүнтэй холбоотой асуудал, хил хамгаалалтын талаар улсын хэмжээнд баримтлах бодлогыг нэгтгэн зангидах, явуулж буй үйл ажиллагааг уялдуулан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор тухайн үеийн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн тухай хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, эрх зүйн орчныг оновчтой болгоно” гэж заасныг үндэслэн Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг боловсруулж, 2002 онд Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж, одоог хүртэл мөрдөгдөж байна.

Энэхүү тулгуур баримт бичиг нь улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад чиглэсэн, улсын хилийн аюулгүй байдлыг хангах механизм, түүнийг хэрэгжүүлэх зорилго, зорилт, зарчим, үндсэн чиглэлийг тусгасан үзэл санааны тогтолцооноос бүрдэж буй бөгөөд төрийн бодлогын залгамж чанарыг хангах чухал үүргийг гүйцэтгэж ирсэн.

Монгол Улсын хил хамгаалалтын бодлогыг хэрэгжүүлэхэд хэд хэдэн саад бэрхшээл гарч байгаа бөгөөд эдгээрийг шийдвэрлэх зорилгоор хилийн бодлогын шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хилийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт, төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр заасан ч, энэ чиглэлд ахиц дэвшил гараагүй байна. Хилийн аюулгүй байдлыг хангах бүхий л үйл ажиллагаа уялдаатай, зохицуулалттай

байх ёстой бөгөөд зөвхөн Хил хамгаалах байгууллагын асуудал биш, улс орны бүх салбарт холбоотой асуудал юм.

Тиймээс, Монгол Улсын хил хамгаалалтын бодлогыг улс орны нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, цаг үеийн эрэлт хэрэгцээг харгалзан шинжлэх ухааны үндэстэйгээр шинэчлэн боловсруулж, хэрэгжилтэд нь анхаарал хандуулж, холбогдох бүх талуудын хамтын ажиллагааг сайжруулах нь чухал юм. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг илүү үр ашигтай, оновчтой болгох нь Монгол Улсын хилийн аюулгүй байдал, ард иргэдийн хамгаалалт, улс орны аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

Монгол Улсын Засгийн газар, Хил хамгаалах байгууллага холбогдох субъектээс “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг бүрэн утгаар хэрэгжүүлснээр энэ талаар баримтлах бодлого цэгцтэй болж, түүний залгамж чанар хангагдан, ямар ч засаглалын үед мөрдөгдөх тулгуур баримт бичиг болох ба улсын хил түүнтэй холбоотой асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж бүрдэж, энэ талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрийг байгуулахад үндсэн баримтлал байх боломж хангагдах нь уг баримт бичгийн гол үзэл санаа юм.

Төрөөс улсын хил, түүний аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого нь тухайн улсын нийгэм, улс төр, эдийн засгийн байдал болон бүс нутаг, хөрш зэргэлдээ улсуудын цэрэг-улс төрийн байдлаас урган гарах ба түүний хэрэгжилт нь доорх нөлөө бүхий хүчин зүйлсээс ихээхэн шалтгаалдаг байна. Үүнд:

- бүс нутгийн болон хөрш улсуудын цэрэг-улс төрийн байдал, улс хоорондын харилцаа;

- улс орны төр, нийгмийн тогтвортой байдал, тухайн улсын олон улсад эзэлж буй байр суурь;

- хөрш зэргэлдээ улсуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн ялгаа, тэдний хил хамгаалалтын байдал;

- улсын хил, хилийн дэглэмийн гэрээний нөхцөл байдал;

- хил хязгаар нутгийн байгаль цаг агаар, газар зүйн онцлог, орон нутгийн засаг захиргааны байгуулалт;

- хил хязгаар нутаг дахь хүн амын нягтрал, тэнд оршин суугч ард иргэдийн бүтэц /үндэс угсаа, зан заншил, гэмт хэрэгт холбогдолтой байдал г.м/;

- хилийн тоноглол /инженерийн байгууламжууд-торон саад, цайз, суваг шуудуу, г.м/;

- хил хамгаалах байгууллагын боловсон хүчний болон анги салбарын байр байдал;

- зэвсэг техникийн хангалт;

- мэдээлэлжүүлэлтийн байдал зэрэг болно.

Үүнээс улсын хил, түүний аюулгүй байдал нь өргөн цар хүрээг хамарсан улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах томоохон арга хэмжээ болох нь харагдаж байна.

### Дүгнэлт, санал

Төрөөс улсын хил, түүний аюулгүй байдлын талаар баримтлах бодлогын хэрэгжилт нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах субъектүүдийн бодлого үйл ажиллагааг улсын хил дээр болон хилийн орон зайд харилцан уялдаа холбоотойгоор төвлөрүүлэх, бодит хүчин зүйлүүдтэй уялдуулж, хамтын харилцан ажиллагааны үр дүнг дээшлүүлснээр хангагдах нь зүй тогтолтой юм.

Монгол Улсын төр засаг улсын хил, түүний аюулгүй байдлын талаар юуны түрүүнд бусад улсын тусгаар тогтнолыг хүндэтгэн үзэхийн зэрэгцээ өөрийн улсын тусгаар тогтнолыг хамгаалах, үндэсний аюулгүй болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын хангах, улсын хилийг улс хоорондын харилцааны гүүр байлгах, халдашгүй дархан байлгах бодлого баримтлах нь чухал байна.

Дэлхийн болон бүс нутгийн улс төр, нийгмийн өнөөгийн байдал, хөрш орны батлан хамгаалах бодлогоос харахад Монгол Улсын хилийн аюулгүй байдалд ойрын жилүүдэд аюул занал байхгүй ч, урт хугацаанд аюул занал учирч болох магадлалтай байна. Иймд хилийн аюулгүй байдлын хөгжлийн чиг хандлагад дараах



МОНГОЛ УЛСЫН  
ХИЛ ХАМГААЛАХ  
БАЙГУУЛЛАГА



ХИЛ СУДЛАЛ

бодлогын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

1. Улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт цэргийн аюул, хурцадмал байдал, зэвсэгт болон зэвсэггүй мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх талаар улс хоорондын хэлэлцээр байгуулах,

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гэсэн гуравдугаар бүлгийн “Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал” хэсэгт 3.1.2.8 дугаар заалт болгож, “Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт хөрш орнуудтайгаа харилцан итгэлцэл, ойлголцол, олон улсын эрх зүйн хүрээнд “нэг хил, хоёр улс” зарчимд тулгуурлан улсын хилийн аюулгүй байдлыг хамтран хангана” гэсэн өөрчлөлтийг УИХ-д өргөн барьж, тусгуулах;

3. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого болон бусад холбогдох хуулиудад “Хилийн аюулгүй байдлын тухай” нэмэлт, өөрчлөлт оруулах;

4. Монгол Улсын Засгийн газраас Хилийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дүгээр заалтыг хэрэгжүүлж “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх, байгууллага иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам” гаргаж мөрдөх, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хилийн аюулгүй байдлыг хангах харилцан ажиллагааг энэхүү журмаар зохицуулах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

5. Хил орчмын бүс нутагт хүн амын төвлөрөл бага байгаа нь Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйдэх хандлага болж байна. Иймд улсын хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдийн татвар болон эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг хөнгөвчлөх, алслагдсан бүс нутгийн урамшуулалтай болгох эрх зүйн орчин бүрдүүлэх зэрэг болно.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт нь улс орны хөгжлийн бодлого, олон улсын харилцаа, аюулгүй байдалд томоохон нөлөө үзүүлнэ.

### Ашигласан материал

Монгол Улсын Их Хурал. (2010). *Монгол Улсын Үндсэн хууль (1992 оны шинэчлэгдсэн найруулга)*. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2016). *Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль*. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2001). *Үндэсний аюулгүй байдлын тухай хууль*. Улаанбаатар.

Монгол Улсын хилийн тухай хууль. (2016). *Монгол Улсын хилийн тухай хууль*. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2002). *Төрөөс хилийн талаар баримтлах бодлого: Монгол Улсын Их Хурлын 20 дугаар тогтоол*. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2010). *Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал: Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол*. Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн газар. (2010). *Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрүүд*.

Дотоод хэргийн их сургууль. (2018). *Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам: Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Хууль сахиулахуй сэтгүүл, 3(17), 45–56*.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хил орчмын хамтын ажиллагаа зөвлөлдөх уулзалтын материал. (2005). *Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хил орчмын хамтын ажиллагаа зөвлөлдөх уулзалтын материал*. Улаанбаатар.

Арвай, Ш. (1995). *Монгол Улсын төрийн хилийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр буюу “Хил”*. Улаанбаатар.

Нямдорж, Д. (2011). *Хил судлал*. Улаанбаатар.

Улаанхүү, Ч. (2014). *Аюулгүй байдал*. Улаанбаатар.

Арвай, Ш. (2015). *Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог*.  
Бердимурат, М. (2013). *ОХУ-ын төрөөс хилийн талаар баримталж буй бодлого, туршилага*. Улаанбаатар.

Ганболд, Ц. (2022). *Хил судлал*. Улаанбаатар.  
*Хил судлал сэтгүүл*. (2023). 01(28). Улаанбаатар.  
*Проблемы пограничной политики государства и пути их решения*. (2001). Москва.



Дотоодын Ажлын Яаман